



ЗУРБ Э.Мөнхмарал-у

Б.Цэнгэл 9/30

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 175

Улаанбаатар хот

**Төрийн өмчит компаниудын
Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус
гишүүдийг чөлөөлж, томилох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хорооноос ирүүлсэн дүгнэлтийг харгалзан 1 дүгээр хавсралтад заасан хараат бус гишүүдийг улируулан сонгосугай.

2. Төрийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийн 2 дугаар хавсралтад заасан хараат бус гишүүдийг 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

3. Авлигатай тэмцэх газрын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 05/9168 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг харгалзан төрийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлд 3 дугаар хавсралтад заасан хараат бус гишүүдийг 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.

4. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг судалж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг хараат бус гишүүдэд, мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргуулан авахыг компанийн эрх бүхий албан тушаалтнуудад тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132005446
12-r_huraldaan.docx


Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 175
дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт



ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС ЧӨЛӨӨЛӨГДӨХ
ХАРААТ БУС ГИШҮҮДИЙН НЭРС

Д/д	Хуулийн этгээдийн нэр	Төрийн эзэмшлийн хувь	Чөлөөлөгдөх хараат бус гишүүд
1	"МИАТ" ТӨХК	100	О.Гэрэлмаа П.Баатарсүрэн Т.Болдоо

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны ...05... дугаар сарын ...11...-ны өдрийн
175... дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт



ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛД ТОМИЛОГДОХ ХАРААТ
БУС ГИШҮҮДИЙН НЭРС

Д/д	Хуулийн этгээдийн нэр	Төрийн эзэмшлийн хувь	Шинээр томилогдох хараат бус гишүүд
1	"МИАТ" ТӨХК	100	Г.Даваа Д.Нямаа Г.Энхмаа